

МОНГОЛ ХЭЛНИЙ АДИЛТГАЛ ҮГ ХЭЛЛЭГИЙН
ХЭЛЗҮЙ, УТГАЗҮЙН СУДАЛГААНЫ АСУУДАЛД

Ж.Бат-Ирээдүй, Р.Алтансайхан¹

Адилтгал бол хүний танин мэдэх, ухаарал, сэтгэхүй, сэтгэлгээний үр дүнгийн илэрхийлэл бөгөөд үндэстэн тус бүрийн ахуй орчин, байгаль дэлхий, уламжлал удамшил, зан заншил, соёл түүхийн ялгаанаас шалтгаалан улс үндэстэн бүрд өөр өөр байдаг зүйл байна. Бид монгол уран зохиолын 400 орчим өгүүллэгийг шүүн үзэж, аль болох хангалттай хэмжээний жишээ баримт цуглуулж монгол хэлний адилтгал үг хэллэгийн хэлзүй, утгазүйн ерөнхий болон өвөрмөц онцлогийг ажиглаж, монгол хэлний адилтгал үгийн онцлог, монгол хүний жиших адилтгах сэтгэлгээний парааг ерөнхийд харах гэж оролдлоо. Ер нь хэлний үгийн сангийн судалгаа хийхэд хангалттай бөгөөд баталгаатай жишээ баримт дээр түшиглэж дүгнэлт хийх нь маш чухал юм.

Адилтгал бол хэрэглээгээрээ маш өргөн бөгөөд өдөр тутмын яриа хэлнээс утга зохиолын төрөл бүрийн найруулгад хүртэл бас их өргөн хэрэглэгддэг хэлний онцгой хэрэглүүр юм. Хэлшинжлэлийн онолд метафорыг ялгах утгын онцлогийг харгалзан “metaphor, simile, personification, paradox, metonymy, oxymoron, apostrophe, chiasmus”² гэж хэдэн янзаар ангилсан байна. Монгол хэлний баримт хэрэглэгдэхүүнийг шүүн үзвэл адилтгалын дээрх төрлийн ихэнхи нь бий гэж үзэж болно.

“Хэлний тэмдэг нь бодот ертөнц, хийсвэр ертөнцийг хамтад нь иж бүрнээр нь тусган тэмдэглэх хэрэглүүр болж чаддаг. Харин “бодот ертөнц, хийсвэр ертөнц хоёрын дунд ‘боломжит ертөнц’ хэмээх бас нэг өвөрмөц ертөнц ‘орших’ бололцоотой байдаг бөгөөд энэ нь адилтгал, зүйрлэл, хэлц үг, хэллэг, хоршоо үг хэллэг зэрэг хэлний тогтвортой нэгж бөгөөд дээрх гурван ертөнцийн тусгал-тэмдэглэхүүн”³ ажээ. Энэ тэмдэглэхүүн нь мөн юмыг шууд биш дам нэрлэсэн байдгаараа хэлний бодит нэрлэлтээсээ ялгаатай билээ. Мөн хэлний хэлзүйн болон үгийн сангийн янз бүрийн арга загвараар бүтэж болох бөгөөд энэхүү тогтолцоог судлан гаргах нь монгол хэлний үгийн сан, утга, хэлзүйн судалгааны бас нэг чухал тал болох юм. Хэдийгээр “хэлний холбоо үг, өгүүлбэр бүтэх бүтцийн загварыг хэлний агуулгын талын хэлбэрээр нөхөж бөглөх тохиолдлын тоо нь хязгаарлашгүй боловч ертөнцийн юм үзэгдлийн хоорондох бодот шалтгаалалцсан хамаарал нь хэлний агуулгын талын хэлбэрүүд холбоо үг, өгүүлбэр бүтэх загварын дагуу өөр хорондоо чөлөөтэй холбогдох боломжийг хязгаарлаж байдаг зүй тогтолтой

1. Монгол Улсын Их Сургууль

2. David Crystal, “The Cambridge Encyclopedia of Language”, CUP, 1987, pp.70

3.

Ж.Бат-Ирээдүй, Р.Алтансайхан

ажээ. ”⁴ Монгол хэлний адилтгалын хэлзүйн хэв шинжийг авч үзвэл тийм ч олон тоо томшгүй зүйл биш бөгөөд харин ч тодорхой тооны тогтсон хэвшинжээр хязгаарлагдаж харин дотоод сэтгэлгээний онцлог нь хязгаар хярхаггүй тэлэх тийм боломжтой юм уу гэсэн төсөөлөл ажиглагдаж байна.

Монгол уран зохиолын баримт хэрэглэгдэхүүнүүдийг ажиглавал хэлзүйн талаасаа монгол хэлний адилтгалыг бүтээж байгаа хэлний хэрэглүүрийн загвар бүтцэд доорх ерөнхий хэв маяг ажиглагдаж байна гэж үзэж болох юм.

1. –аар¹ (аргалын шээзгийд багтчихаар, бухан бярууны аранишингаар, олон бүргэдийн харцаар, тасын дэвэлтээр, эмээлтэй морио алдаж, явгарсан хүний нүдээр гм)

2. –аас¹ (бөхийсний бүснээс, хазайсны хажуугаас гм)

3. нэр үг + адил (аварга могойн нүд адил, булгийн усны урсгал адил, гарын алга урвуулах адил, зүүний үзүүр адил, зэрлэг бугын адил, өлссон чоно адил, усны урсгал адил, гм)

4. нэр үг + аятай (зөгий хатгах аятай, тэмээний хавирга аятай, ялааны үхэр аятай гм)

5. гэлтэй (алганы илч гэлтэй, арьсандаа багтаж ядав гэлтэй, газрын гавгаар оров уу гэлтэй, хоёрдугаар багийн дансыг уншиж байна уу гэлтэй, гм)

6. гэмээр (иймхай мөгөөрснөөсөө эхэлсэн юм уу гэмээр, дарь эх гэмээр, газрын мухар гэмээр, гм)

7. лугаа (ёлоох лугаа, мөсний хэлтэрхий унах лугаа, хөх өвсний түймэр лугаа гм)

8. лүгээ адил (будaa түүх тагтаа лүгээ адил, олон чоно лүгээ адил, гм)

9. лүгээ нэгэн адил (зун цагийн тэнгэрийн дуу лүгээ нэгэн адил гм)

10.–м (алга дарам, гэрэлд сүү сүвлэм, зүрх царцам, нас уртсам, нохой гаслам, гм)

11.–маар¹ (агаарт дэгдэж, үүлэнд умбан алдмаар, гэр хагармаар, малын им тамга харагдмаар, хизаад авмаар, худгийн онгоц хага хэгсмаар, гм)

12. мэт (аалз мэт, бэлэвсэн эхнэрийн нулимс мэт, гаансны толгой мэт, хатсан үдээр мэт, эрхи мэт гм)

13.–тал¹, (алиг толгодыг босож суутал, газар доогуур ортол, сүнс зайлтал, гм)

14. чинээ (алганд багтахын чинээ, гэрийн буурин чинээ, самбайн чинээ, утсан чинээ, гм)

15. шиг (аавын духны үрчлээ шиг, аалзны шүлс шиг, адсага шиг, борц шиг, галд хаясан төмөр шиг, уул шиг, уулын согоо шиг, хөдөөлсөн бух шиг, янгир шиг, гм)

16. –сан¹ (аавдаа алт болсон, ээждээ эрдэнэ болсон, биеэ гайхуулсан, гэрэлт нар болсон, гм)

4. Ж.Баянсан, “Адилтгал – ертөнцийн тухай хэлний дүр зураг”, “Соёл, хэл, сэтгэлгээ” Уб., 2002, 17 дахь тал

Ж.Бат-Ирээдүй, Р.Алтансайхан

Монгол хэлний метафорын зарим хэсгийг хэлзүйн бүтэц болон утгын талаас нь судлаж “дүрслэлт чимэг тодотгол” гэж нэрлээд түүний утга хэрэглээг хүний танин мэдэхүй, сэтгэлгээний үйл явц, үр дүн талаас нь тодотгогч, тодотгуулагчийн харьцаанд шинжилсэн судалгаа чухал байгааг дурдаад эх сурвалж нь амьтан заасан, байгалийн юм үзэгдэл заасан хэмээн ангилж хийсэн судалгаа⁵ ч бий.

Адилтгал зүйрлэл бол хэлний тогтвортой нэгжийн хамгийн их хувийг эзэлдэг үзэгдэл бөгөөд монгол хэлний үгийн сан, утга судлалын сонирхолтой судлагдахууны нэг юм. Адилтгалын гол мөн чанар нь аливаа хоёр зүйлийг жишин харьцуулах чанар л юм. Жишин харьцуулахдаа хүн өөрийнхөө хамгийн сайн мэддэг буюу өөртөө хамгийн ойр байдаг тэр зүйлийнхээ адил төстэй шинжээр нь дүйлгэж адилтгах нь угаасаа хүн төрөлхтөний сэтгэлгээний онцлог юм. Хүн ямар орчинд хаана амьдарч, юуг харж, юу мэдэрч өсөж хөгжиж байна гэдгээс шалтгаалаад аливаа зүйлийг янз бүрээр адилтгаж, зүйрлэж, жишдэг нь зүй юм. Харьцуулахад хязгаар гэж үгүй ч хэм хэмжээ, зүй тогтол гэж буй.

Монгол хүний хувьд ялгаагүй амьдралын туршлагаас алив байгаль, юмс үзэгдлийн шинж чанар танин мэдсэний үндсэн дээр хоёр өөр юмс үзэгдлийг өөр хооронд нь адилтган нэрлэдэг байна. Адилтгал үг хэллэгийн гол мөн чанар нь өгүүлэх зүйлийнхээ шинж байдлыг тодруулах явдал юм. Аливаа өөр өөр үндэстний сэтгэлгээний онцлогийг тодорхой нэг зүйл дээр авч үзвэл тухай тухайн ард түмний сэтгэлгээний онцлог их тод харагдана. Адилтгал нь тухайн ард түмний ертөнцийг танин мэдэх, ухаарах, танин мэдэх, цааш нь тайлбарлан таниулах, сэтгэлгээний онцлогийг илэрхийлэх, аливаа зүйлд үнэлгээ, үнэлэмж өгөх үндэстний сэтгэлгээний онцлогийг харууллагаараа бусдаас онцлогтой гэж үзэж болно.

Монгол хэлний адилтгал үгийг ажиглавал байгаль орчин, мал аж ахуй, хүний бие мах бод, зан харьцаа, амьдралын өдөр тутмын үйл хөдлөл, шашин шүтлэг, ёс заншил, аж төрөхүйн онцлогийг тусгасан адилтгал үг ихэнхийг эзэлж байна. Угаасаа ч үндэстэн ястан бүрд ийм онцлог байх ёстой тухай дээр дурдсан. Тухайлбал, малын шинж төрх, эд эрхтэн, хариулга маллагаа, ааш аягийг харуулсан адилтгал үг хэллэг (*бухан бярууны араншингаар, ямаанаас янзтай, тэмээнээс тэмдэгтэй, азарга унагалахтай адил, адууны хомоол адил, бөхгүй тэмээ адил, нүцгэн хөх тэмээд адил, уяаны морь адил, хаврын яргуй, ачаа нь хүндэдсэн тэмээ аятай, ялааны үхэр аятай, аргал, усны үхэр шиг, ботгоо голсон ингэ шиг, бухссан гунж шиг, бурантагдуулсан тэмээ шиг, ноосоо хөглөрүүлсэн тэмээ шиг, эдэлгээний морь шиг, яргуйны ямаа шиг гэх мэт*) олон байна.

Хүний зан араншин, харилцааг илэрхийлсэн адилтгал үг хэллэг (*эмээлтэй морио алдаж явгарсан хүний нүдээр, сүүдрээс өөр нөхөргүй, сүүлнээс өөр ташуургүй, дарь эх гэмээр, гэрэлд нь зүү сүвлэм, зүрх царцам, нас уртсам, овдөгнөөс нь адис авмаар, уншсан хэдэн маанца шатаамаар, хазаад авмаар, бэлэвсэн эхнэрийн нулимс мэт, лам хүн хонь алахыг үзсэн мэт, төрөл арилжсан мэт, хуруу хумсаа барагдтал, иавын духны үрчлээ шиг, алагиараа харж, арваараа барьсан шиг, буруу ишлэсэн сүх шиг, нөмгөн чавганц шиг, хөхүүл хүүхэдтэй юм шиг, хурц хутга сул өвөртөлсөн хүн шиг*) бас ихэнхи хувийг эзэлнэ.

5. Б.Мөнхтуяа, Д.Чимэгбаатар, “Дүрслэлт чимэг тодотголоор өгүүлэгчийн үнэлэмж илрэх нь”. Монгол судлалын чуулган, 2012, №12(47)8 49-54 дэх тал.

Ж.Бат-Ирээдүй, Р.Алтансайхан

Мөн мал аж ахуй эрхэлдэг малчин удмын монголчууд амьтны төрх, байдлыг дүрслэн илэрхийлсэн адилтгал (*ангирын зулзага адил, өлссөн чоно адил, цаст уулын цагаан арслан дугаа, сүүл салтаадсан гөлөг мэт, хурга барьж буй чоно мэт, ачаа дагасан нохой шиг, бутано шахуулсан туулай шиг, доргүй бух шиг, зодуулсан голөг шиг, нүхээ олохгүй хулгана шиг, сүү долоосон гөлөг, үнсэнд хаягдсан шалз шиг, хээлтэй гичий шиг, яс горьдсон нохой шиг, ятги шаазгай шиг*) маш их хэрэглэдэг байна.

Байгаль дэлхийн үзэгдэл, онцлогийг ажиглаж байдаг ажигч монголчууд (*булгийн усны урсгал адил, зуны эхний сарын 11р цайж буйн адил, огторгуйд түгсэн од дугаа адил, шинэ сарын адил, элсэнд ус шингэх адил, тэмээний уруул хагалам, одрийн од мэт, хаврын түймэр мэт, арван тавны сар шиг, зэрэглээ шиг, үлий сахисан сар шиг, үүлээ хөөсөн хаврын тэнгэр шиг, үүрийн гялаан, үдийн цолмон хоёр шиг, хаврын тэнгэр шиг, цэцэг дэлгэрэх шиг*) гэх зэрэг адилтгал үг хэллэгийг сэтгэн боджээ.

Мөн цааш ажиглавал нүүдэлчдийн амьдралын хэв маягаас үүдэлтэй хүний ахуй амьдрал хэв маягийг илэрхийлсэн үг хэллэг монгол адилтгал үгийн санд (*сармай дээлтэй эмгэн аргал түүх адил, үдийн будаа идэхтэй адил, ачаа нь хүндэдсэн тэмээ аятай, асаатай зул мэт, эссэн айриг мэт, аргалын шаваас шиг, бүрэлдсэн тариг шиг, дэлгэцтэй хурууд шиг, загссан өрөм шиг, зулсан эсгий шиг, ташуурын сур шиг, тогооны бариул шиг, хонхны хэл шиг, хэхэрсэн худаг шиг, шахсан бяслаг шиг, ээрүүлийн утас шиг зэрэг*) томоохон жин дарж байна.

Мөн монгол хүн хоёр өөр юмсийг адилтгаж жишихдээ шууд бус дам нэрлэх ба энэ адилтгаж буй шинж байдлыг тодруулах, хүний сэтгэхүй өгөгдөл (амьдралыг таниж мэдсэний үр дүн, сэтгэхүйн өвөрмөц үйлдэл) өөр дамжуулан төсөөлөх өндөр чадамжтай гэж үзэж болно. Жишээ нь адилтгаж буй зүйлийн хэмжээг бага, жижиг, овор бага, багахан хэмээн шууд нэрлэлгүй *алганд багтахын чинээ, алгын чинээ, малгайн чинээ, оодсон чинээ, утсан чинээ, 11хэлцгийн чинээ, тойгон чинээ, тохмон чинээ, тохойн чинээ, хүмсын чинээ, хуруун чинээ, чигчийн чинээ, шагайн чинээ, шар будаан чинээ* гэх мэтээр адилтгах зүй тогтлын дагуу дүрслэн ярьж бичдэг нь монгол хэл болоод монгол хүний хийсвэрлэн сэтгэж утга санааны төгс байдлыг бий болгож байгаатай холбоотой юм. Том, томоохон, овор хэмжээ их гэх санааг илтгэх *гэрийн буурин чинээ, гэрийн чинээ, данхан чинээ, тавхайн чинээ, талын чинээ, тоонон чинээ, тоорцгон чинээ, тохмон чинээ, тохойн чинээ* гэх зэрэг адилтгал ч түгээмэл хэрэглэгддэг.

Түүнчлэн “чинээ” гэх холбоосоор алив зүйлийн хэмжээг адилтгахаас гадна юмс үзэгдлийн мөн чанар, үнэт зүйлсийг тодорхойлсон нь жишин адилтгах үг хэллэгийн судалгаанд онц сонирхолтой өвөрмөц сэдвийн нэг болно. *Богтосын чинээ, нохойн чинээ, оодсон чинээ, самбайн чинээ, утсан чинээ* зэрэг үг хэллэг нь адилтгаж байгаа зүйлийн мөн чанар, үнэ цэнийг маш тодорхой харуулж байгаагаараа онцлог юм.

Дээрх хэмжээ илэрхийлэх адилтгал үг хэллэгээс гадна өнгө зүсийг харуулсан дараах (*болсон алим адил, сувдан сондор мэт, тэнгэрийн үл мэт, сувд мэт, тогооны хөө шиг, лавайн адил зэс мэт, усны замаг мэт, хох исар мэт, борооны өмнөх тэнгэр шиг, гангир шаазан шиг, ноосолчихсон тэмээд шиг*) жишээ байна. Цаашилбал тоо, дуу чимээг илэрхийлэх адилтгал үг хэллэг ч олон байна.

Ж.Бат-Ирээдүй, Р.Алтансайхан

Мөн адилтгал үг хэллэгийг монгол хүний сэтгэлгээ, сэтгэхүйн үйлдэлтэй холбож тайлбарлах хэрэгтэй билээ. Аливаа амьд организмын гадаад орчны талаарх анхдагч мэдээллийн үр дүн нь сэрэл байдаг. Жишээ нь: “тэмээний уруул хагалам” “Энд бүтэн сар бороо хур ороогүй бүр гандаж, тэмээний уруул хагалам халуун салхи Гурван сайхан уулсын хэдэн хөтлөөр нэвт сүүгэн тэр чигээрээ тал говь хөвсөлзүүлж эл бяцхан сууринг бас бөгчимдүүлжээ.” (С.Пүрэв, “Богинохон зун”) гэснээр монгол хүний нүүдэлчин амьдралын эмпирик сэрэл буюу “халуун салхи” гэж хэлээд ойлгогдох атал сэтгэхүйн хамгийн эгэл хэлбэр болох оршин буй зүйлийг илтгэх цаашилбал юмс үзэгдэлд нэр өгч ойлголтыг бүтээх үйл тул хүртэхүй бас бодомж болж байна. Тэгтэл говийн халууныг, тэмээний уруул хагалахтай адилтгал болгож “-м” нөхцөлийг холбоосоор илэрхийлэх нь сэтгэц хэл шинжлэлийн хувьд тодорхой өнгө аясын тусламжтайгаар юмсын үнэ цэнийн талаар илэрхийлж буй хэлний “адилтгах” хэлбэр сэтгэхүйн хувьд “мэдрэхүй” болж байна. Хэдийгээр мэдрэхүй нь хамгийн иррациональ шинжтэй сэтгэцийн үзэгдэл боловч монгол хүний “хэл сэтгэхүй”-н хувьд энэ утга илэрхийлэх хамгийн дээд чадварын нэг нь адилтгал буюу адилтгах зүй тогтол гэж үзэж байна.

Бид уран зохиолын яруу адилтгал, зүйрлэл хэрэглүүрийн хэлний үүргийг судлахдаа илэрхийлж буй утгыг тайлбарласан юм. Энэ нь уран зохиолд уншигчийн санаанд уран яруу байдлаар дүрслэгдэж зохиолын дүр дүрслэлийн уран тод, тансаг байдлыг илэрхийлэх хэрэглүүр, хэлний хувьд нэг үг (том гэхийг үхэр чулуу мэт)-ийг өөр үгсээр баяжуулж адилтган жишиж болохыг харуулна.

Юмсын оршин буй нь сэрэл сэтгэхүйгээр тодорхойлогдож, мэдрэмжээр үнэ цэнийг илэрхийлэх ба хэл шинжлэлд үүнийг илэрхийлэхэд “Адилтгал үг хэллэг” чухал үүрэг гүйцэтгэж байгаа юм. “Гэтэл дүрт сэтгэлгээ буюу уран сайхны сэтгэлгээ нь ч мөн адил дурдсан танин мэдэхүйн олон хэлбэрүүдийн нэг бөгөөд гагцхүү танин мэдэхүйн арга зам нь туйлын өвөрмөц, стандарт бус арга байдаг” “Художественная литература как познавательная деятельность” (В.Е.Хализев “Теория литературы” М.1999, стр.22) Жишээ нь дутуу загссан өрөм мэт ≈ нимгэн, сарсгар, сийрэг “Үл ялиг дорсгой шар шүдтэй, цагаан бурхны сорви дутуу загссан өрөм мэт цоохортсон бахимхан хужаа бол Цоохондой.” (Д.Пүрэвдорж, “Тарчилсан сүнс”) гэсэн нь гадаад төрх нь “цоохор царайтай” байхад хүний үл ухамсарлахуйд хадгалагдан үлдсэн (өгүүлэгч нь өмнө тогооны өрөм дутуу загссан улцан, цоохор байдлыг харсан, тэр нь оюун санаанд түлхүүрлэгдэн хадгалагдсан) “дутуу загссан өрөм”-ний зураг сэтгэц задлагийн үйлдлээр дамжих илэрхийлэлд “Адилтгал үг хэллэг”-ийн үүрэг илүү тодорхой харагдаж байна.

Аливаа хүнд өөрийнх нь туулсан амьдрал ахуйнх нь тухай тодорхой санаа болон дүр зураг ил ба далд ухамсарт нь хадгалагдсан байдаг. “Үл ялиг дорсгой шар шүдтэй, цагаан бурхны сорви дутуу загссан өрөм мэт цоохортсон бахимхан хужаа бол Цоохондой.” гэсэнд үл ялиг дорсгой шар шүдтэй, цагаан бурхны сорви гэсэн нь ухамсарт харагдах дүр бол дутуу загссан өрөм мэт ухамсарт бус агуулга ба энэ хоёрыг холбох нь адилтгал болно. Сэтгэхүй нь юмс үзэгдэлд нэр өгч ойлголтыг бүтээх бол адилтгал нь хоёр өөр юмсыг өөр хооронд нь жишин үзсэнээрээ адилтгагчийг улам бүр тодруулж дүрсэлж өгдөгөөрөө онцлог юм. Иймээс дүр нь юуны өмнө тодорхой нэг төсөөлөл бөгөөд өөрөөр хэлбэл аливаа үзэгдэл юмс, баримт хэрэглэгдхүүн, үйл явдал зэрэг ямар нэг зүйлс тэдгээрийн сэтгэл мэдрэхүүд төсөөлөгдөж буй тэр дүр төрхийн хүний ухамсар оюун дахь тусгал юм. Эндээс адилтгах сэтгэхүй, адилтгах зүй тогтол үүсдэг.

Ж.Бат-Ирээдүй, Р.Алтансайхан

Харин адилтгал нь уран сайхны адилтгал байх ёстой буюу гоо зүйн мөн чанар, түгээмэл хууль, нийтлэг зүй тогтол, ерөнхий хуулиудыг өөртөө агуулж түүнд захирагдсан байх цорын ганц болзолтой байдаг. Энэхүү адилтгалын үр дүнд тухайн текстэд /тухайн зохиолын хэлний байгууламжид/ буюу өгүүлэмжид огт байхгүй цоо шинэ утга санаа болох шинэ дүр үүсч бий болно. Адилтгагч адилтгуулагч хоёрын харилцан тусгалцах явцын үр дүнд шинээр үүсч буй гуравдагч зүйл буюу санааг л чухамдаа гаргаж байгаа нь адилтгал үг хэллэгийн гол ач холбогдол, үүрэг болж байгаа юм. Жишээ нь: цэцэг цэврүү шиг “Эднийх цэцэг цэврүү шиг ганц охинтой. Тэр бас л аав шигээ эршүүд зантай. баахан хэнэггүй нэгэн.” (С.Пүрэв, “Шар усны үер”), “Дөлгөөн эгч насандаа ч үсэндээ сам хүргэж үзээгүй болов уу гэмээр сэгсгэр нэгэн, харин ааш зан, унд ус сайтаагаараа нутаг орондоо гайхагдана. Цэцэг цэврүү шиг ганц сайхан охинтой, тэр охиныг Гандулам гэнэ.” (С.Пүрэв, “Хөхбүрдийн намар”), “Таныг чинь цэцэг цэврүү шиг охинтой болсон гэж дуулаад яарч ирлээ гэсээр мөнөөх эмсгий шар залуу тэргэн дээрх ачаагаа онгичин шуудайтай юм гаргаж өгөхдөө” (С.Пүрэв, “Өвгөн охин хоёр”), “Нармандах ямар чихэр бурам шиг ааштай хүүхэн байлаа. Ямар цэцэг цэврүү шиг амьтан байлаа.” (Ж.Лхагва, “Миний хонгор хотод бий”), “Яахав гэнэ шүү. Цэцэг цэврүү шиг ганц охиноо шалдан хар юманд зүүгээд шалбааганд хаях гээ юу. Цаад наадахыг нь хардаг байгаа даа.” (Д.Пүрэвдорж, “Тарчилсан сүнс”) гэсэн дүрслэлд цэцэг цэврүү хоёр өөр өөр утга бүхий үг атал нийлүүлээд шиг холбоос залгахаар энэ адилтгал үг хэллэгт “энхрий”, “нандин”, “чамин”, “эмзэг”, “турьхан” гэсэн утга, түүнийг илэрхийлэн томьёолсон хэлний өгөгдхүүн огт байхгүй боловч гагцхүү адилтгах шиг холбоосын үр дүнд зүй тогтлын дагуу “энхрий”, “нандин”, “чамин”, “эмзэг”, “турьхан” хэмээх утга шинээр үүсчээ.

Адилтгал нэг төрлийн дүр, дүрслэл нэг төрлийн тэмдэг, нэг төрлийн төсөөлөл юм.

Ж.Бат-Ирээдүй, Р.Алтансайхан
НОМЗҮЙ

[David Crystal] David Crystal, "The Cambridge Encyclopedia of Language", CUP, 1987, pp.70

[Баянсан Журын] Ж.Баянсан, "Адилтгал – ертөнцийн тухай хэлний дүр зураг", "Соёл, хэл, сэтгэлгээ" Уб., 2002, 17-21 дэх тал

[Мөнхтуяа Б] Б.Мөнхтуяа, Д.Чимэгбаатар, "Дүрслэлт чимэг тодотголоор өгүүлэгчийн үнэлэмж илрэх нь", Монгол судлалын чуулган, 2012, №12(47)8 49-54 дэх тал.

[Бат-Ирээдүй Ж] Ж.Бат-Ирээдүй, Р.Алтансайхан, "Монгол хэлний адилтгал үг хэллэгийн сан", Уб., 2012,

The author's object was to depict Mongolian metaphors, its characteristics, grammatical structure, meaning and roles and the differences of these with certain examples.

Their also strives to show that Mongolian metaphors are important means of demonstrating the ways in which a Mongolian person learns thinks and views life.

This can be seen from examples from Mongolian literature. Authors also states how Mongolian is very unique from many other languages.